



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн “Гүний-Ус” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОМА-2026/028/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaaja@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 322
танай -ны № -т

ГҮНИЙ УС ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.БАДРАЛТХҮҮ ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Гүний ус" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас "Гүний ус" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн байдлын тайланд тусгасан авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтаар нотлогдохгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн, ерөнхий нягтлан бодогч, нярав солигдоход эд хөрөнгийн болон төлбөр тооцооны талаар тооллого хийгээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөлж өргөн тархсан байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.2, 18 дугаар зүйлийн 18.1, 18.3, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.1, 16.1.4 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга, ангилал, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626050563

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд "Цэгцтэй гэр хороолол" төслийн хүрээнд цэвэр усны 3000 метр шугам, бохир усны 1338 метр шугамаар 127 айл өрхийн хувийн сууцыг төвлөрсөн шугам сүлжээнд холбосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Даланзадгад сумын 10 багийн гэр хорооллын иргэдэд ус түгээх үйлчилгээ үзүүлдэг ус түгээх байранд цахилгааны тэжээлээс үл хамаарал бүхий нарны инвертер суурилуулж, ухаалаг автоматжуулалтын горимоор иргэдэд цагийн хязгаарлалтгүйгээр ундны ус түгээсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуульд заасан богино хугацаанд өргөн цар хүрээг хамруулан шалгах боломжгүй тул эрсдэл бүхий зарим асуудлыг дараагийн аудитаар анхаарах асуудалд тусгав.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	257,296,873.5	142,474,037.0
1.1.02	Дансны авлага	398,837,108.1	316,168,592.1
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,773,032.1	135,939.0
1.1.04	Бусад авлага	660,000.0	660,000.0
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	83,597,118.9	45,960,246.7
1.1.06	Бараа материал	410,837,866.5	403,283,949.9
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	20,283,817.8	0.0
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,173,285,816.8	908,682,764.7
1.2.01	Үндсэн хөрөнгө	37,637,614,953.9	48,711,802,062.1
1.2.02	Биет бус хөрөнгө	75,288,481.9	88,891,431.5
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	37,712,903,435.7	48,800,693,493.6
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	38,886,189,252.5	49,709,376,258.3
2.1.1.01	Дансны өглөг	22,131,442.8	3,625,708.4
2.1.1.03	Татварын өр	79,220,442.1	176,857,874.0
2.1.1.06	Хүүний өглөг	831,618,953.1	909,281,543.7
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	35,323,948,116.3	46,051,827,705.0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	36,256,918,954.2	47,141,592,831.1
2.1.2.01	Урт хугацаат зээл	648,202,229.0	571,534,111.7
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	648,202,229.0	571,534,111.7
2.2	Өр төлбөрийн нийт дүн	36,905,121,183.3	47,713,126,942.8
2.3.02	- хувийн	600,552,800.0	600,552,800.0
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	306,871,381.8	306,871,381.8
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	299,802,302.3	299,802,302.3
2.3.09	Хуримтлагдсан ашиг	801,111,427.2	789,022,831.4
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.0	15,181,246.2
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	801,111,427.2	773,841,585.2
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,008,337,911.3	1,996,249,315.5
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	38,913,459,094.6	49,709,376,258.3

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,637,910,073.2	2,806,532,363.5
02	Борлуулалтын өртөг	3,582,319,826.2	5,204,970,598.4
03	Нийт ашиг(алдагдал)	(944,409,753.0)	(2,398,438,234.9)
04	Түрээсийн орлого	3,102,909.1	20,210,000.01
08	Бусад орлого	1,965,402,404.5	2,712,183,093.8
08.1	Орлогын дүн	1,968,505,313.6	2,732,393,093.8
10	Ерөнхий ба удирдлагын зардал	877,709,128.9	316,819,343.9
12	Бусад зардал	7,259,792.6	0.0

12.1	Зардлын дүн	884,968,921.5	316,819,343.9
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	8,213,922.4	0.0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(3,753,164.8)	0.0
17	Бусад ашиг (алдагдал)	76,786,244.9	(266,130.4)
17.1	Олз, гарзын дүн	81,247,002.6	(266,130.4)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	220,373,641.7	16,869,384.62
19	Орлогын татварын зардал	0.0	1,688,138.5
20	Татварын дараах ашиг (алдагдал)	220,373,641.7	15,181,246.2
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	220,373,641.7	0.0
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	15,181,246.2

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	600,552,800.0	306,871,381.8	299,802,302.3	773,841,585.2	1,981,068,069.3
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	600,552,800.0	306,871,381.8	299,802,302.3	773,841,585.2	1,981,068,069.3
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	15,181,246.2	15,181,246.2
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	600,552,800.0	306,871,381.8	299,802,302.3	789,022,831.4	1,996,249,315.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,198,327,571.0	4,688,008,110.0
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,322,785,923.2	3,310,454,481.30
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	120,804,835.0	351,000,001.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	754,736,812.8	1,026,224,018.7
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,959,387,759.4	4,840,467,818.8
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,303,950,184.2	2,026,100,052.6
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	323,383,082.8	390,894,969.6
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	976,548,747.8	1,016,941,484.7
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	425,491,303.1	353,319,412.5
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	247,750,066.8	251,050,922.2
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	469,018,669.5	416,335,407.7
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	15,363,966.0	45,689,951.4
1.2.9	Бусад мөнгөн зарлага	197,881,739.0	340,135,618.1
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	238,939,811.6	(152,459,708.7)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	46,609,505.0	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	46,609,505.0	0.00

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(46,609,505.0)	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	192,330,306.6	(152,459,708.7)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	134,281,504.8	340,893,992.4
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	340,893,992.4	188,434,283.7

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		Хэрэгжилтийн хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Үйл ажиллагааны нийт орлого	мян.төг	4,687,039.9	4,604,603.0	5,538,925.5	120
2	Үйл ажиллагааны нийт зардал	мян.төг	4,466,666.3	4,491,996.5	5,522,056.1	123
Үйл ажиллагааны ашиг/алдагдал		мян.төг	220,373.6	112,606.5	16,869.4	15
Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны нийт орлого		мян.төг	2,819,921.0	3,231,537.9	3,138,217.9	97
4	Цэвэр усны орлого	мян.төг	1,304,292.3	1,251,657.3	1,340,795.4	107
5	Аж ахуйн нэгж, байгууллага	мян.төг	877,566.0	751,707.4	922,088.0	123
6	Ахуйн хэрэглэгч	мян.төг	426,726.2	499,949.9	418,707.4	84
7	Бохир ус татан зайлуулсны орлого	мян.төг	1,177,782.2	1,204,236.9	1,275,271.5	106
8	Аж ахуйн нэгж, байгууллага	мян.төг	817,444.1	847,703.7	925,646.3	109
9	Ахуйн хэрэглэгч	мян.төг	360,338.1	356,533.2	349,625.3	98
10	Суурь хураамжийн орлогын дүн	мян.төг	184,820.2	212,629.7	190,465.4	90
11	Аж ахуйн нэгж, байгууллага	мян.төг	50,420.2	70,241.3	61,880.6	88
12	Ахуйн хэрэглэгч	мян.төг	134,400.0	142,388.4	128584.8	90
13	Үйл ажиллагааны бусад орлого	мян.төг	153026.4	563014.0	331685.5	59
14	Засвар үйлчилгээний орлого	мян.төг	153026.4	243,014.0	331,685.5	136
15	Орон нутгийн татаас/төсвийн/ орлого	мян.төг	0	320.000.0	0	
Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны нийт зардал		мян.төг	3,581,697.3	4,171,996.6	4,240,978.3	102
1	Цалингийн зардал	мян.төг	1,323,589.0	1,565,034.8	2,059,040.7	132
2	Засвар үйлчилгээний зардал	мян.төг	133,761.0	225,466.5	161,277.2	72
3	Ашиглалтын зардал	мян.төг	393,845.7	341,247.9	537,010.7	157
4	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	мян.төг	1,075,635.0	974,859.2	1,211,078.9	124
5	Бусад зардал	мян.төг	654,866.4	1,065,388.1	272,570.8	26
Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны ашиг/алдагдал		мян.төг	(761,776.3)	(940,458.7)	(1,102,760.5)	
Цэвэр усны үйлчилгээний тариф						
1	Айл өрх /тоолууртай/	төг/л	1,200	1,200	1,200	100
2	Айл өрх /тоолуургүй/	төг/л	1,200	1,200	1,200	100
3	УТБайр	төг/л	1,818	1,818	1,818	100
4	Доор дурдсанаас бусад ҮААНБ	төг/л	4,500	4,500	4,500	100
5	Төсөвт байгууллага	төг/л	4,500	4,500	4,500	100

6	Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, мах сүү боловсруулах үйлдвэр	төг/л	4,500	4,500	4,500	100
7	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс, машин угаалга	төг/л	4,500	4,500	4,500	100
8	Зөөвөр	төг/л	5,000	5,000	5,000	100
Бохир усны үйлчилгээний тариф						
1	Айл өрх /тоолууртай/	төг/л	1,200	1,200	1,200	100
2	Айл өрх /тоолуургүй/	төг/л	1,200	1,200	1,200	100
3	Зөөвөр	төг/л	9,000	9,00	9,000	100
4	Доор дурдсанаас бусад ҮААНБ	төг/л	5,200	5,200	5,200	100
5	Төсөвт байгууллага	төг/л	5,200	5,200	5,200	100
6	Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, мах сүү боловсруулах үйлдвэр	төг/л	5,200	5,200	5,200	100
7	Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс, машин угаалга	төг/л	5,200	5,200	5,200	100
8	Зөөвөр	төг/л	9,000	9,000	9,000	100
Нийт хэрэглэгчийн тоо		тоо	20,632	22,087	23,569	107
1	Ахуйн хэрэглэгч	тоо	20,144	21,595	22,981	106
2	Айл өрх /тоолууртай/	тоо	5,239	5,716	6,617	116
3	Айл өрх /тоолуургүй/	тоо	379	379	388	102
4	УТБайр	тоо	14,526	15,500	15,976	103
5	ҮААНБайгууллага	тоо	488	492	588	120
9	Зөөвөр	тоо	7	7	7	100
Борлуулсан усны хэмжээ		мян.м3	1,217.7	1,262.2	1,129.9	90
Цэвэр ус		мян.м3	553.4	558.8	542.2	97
1	Ахуйн хэрэглэгч	мян.м3	366	391.8	337.3	86
2	Айл өрх /тоолууртай/	мян.м3	298.3	311.6	250.4	80
3	Айл өрх /тоолуургүй/	мян.м3	32.1	32.1	64.4	201
4	УТБайр	мян.м3	35.6	48.1	22.6	47
5	ҮААНБайгууллага	мян.м3	187.4	167	204.9	123
6	Доор дурдсанаас бусад ҮААНБ	мян.м3	90.5	57.1	98	172
7	Төсөвт байгууллага	мян.м3	90.3	100.6	96.7	96
8	Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, мах сүү боловсруулах үйлдвэр	мян.м3	6.6	9.3	10.2	110
Бохир ус		мян.м3	459.3	439	452.2	103
1	Ахуйн хэрэглэгч	мян.м3	313	279.5	276.5	99
2	Айл өрх /тоолууртай/	мян.м3	276.2	244.7	205.6	84
3	Айл өрх /тоолуургүй/	мян.м3	32.3	32.1	68.6	214
4	Зөөвөр	мян.м3	4.5	2.7	2.3	85
5	ҮААНБайгууллага	мян.м3	146.2	159.5	175.6	110
6	Доор дурдсанаас бусад ҮААНБ	мян.м3	65.8	52.3	69.7	133
7	Төсөвт байгууллага	мян.м3	71.6	92.9	92.9	100
8	Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, мах сүү боловсруулах үйлдвэр	мян.м3	6.5	9.4	9.8	104

9	Зөөвөр	мян.м3	2.3	4.9	3.2	65
---	--------	--------	-----	-----	-----	----

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 536,441.6 мянган төгрөгийн НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа илэрснээс аудитын явцад залруулсан байна.

Залруулсан алдаа:

- Ерөнхий журналаас бусад орлогыг орлогын дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад 20,377.2 мянга, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 12.0 мянган төгрөг дутуу тайлагнасан,
- Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дэлгэрэнгүй бүртгэлд 14,432.8 мянган төгрөгийн удирдлага борлуулалтын зардлыг, удирдлага борлуулалтын зардалд 446.0 мянган төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
- Санхүүгийн байдлын тайланд тусгасан авлагын бүртгэлийн үлдэгдлээс түүвэрлэн ААН-ын авлагын бүртгэлийг тулган шалгахад 501,173.6 мянган төгрөгийг өөрийн байгууллагаас авахаар бүртгэсэн нь НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар нийт 52,280,114.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 52,280,114.4 мянган төгрөгийн албан шаардлага, сөрөг дүгнэлт авсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага дотоод хяналттай холбоотой зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 52,280,114.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 52,234,050.3 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөлж өргөн тархсан тул "Сөрөг" дүгнэлт өглөө.

3.2 Албан шаардлага

1. Санхүүгийн байдлын тайланд тусгасан 344,234.4 мянган төгрөгийн авлага, 1,089,765.1 мянган төгрөгийн богино хугацаат өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан нь баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Мөнгөн хөрөнгөөс түүвэрлэн шалгахад 155 гүйлгээ буюу 1,109,456.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтаар нотлогдохгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйл 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3. Тайлант онд 3 ерөнхий нягтлан бодогч, 1 нярав солигдоход 49,736,658.5 мянган төгрөгийн эд хөрөнгийн болон төлбөр тооцооны талаар тооллого хийсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

4. Санхүүгийн байдлын тайланд тусгасан авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтаар нотлогдохгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн, ерөнхий нягтлан бодогч, нярав солигдоход эд хөрөнгийн болон төлбөр тооцооны талаар тооллого хийгээгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайлангийн аудитаар "Сөрөг" дүгнэлт авсан гүйцэтгэх захирал Ц.Бадралтхүүд сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Батдоржид даалгав.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Тайлант хугацаанд ажилласан ерөнхий нягтлан бодогч нар хуульд заасан шаардлага хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д "ерөнхий нягтлан бодогч" гэж нягтлан бодох бүртгэл хөтлөх, удирдан зохион байгуулах, хариуцлага хүлээхээр аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагаас томилогдсон мэргэжлийн нягтлан бодогчийг", 18 дугаар зүйлийн 18.3-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ерөнхий нягтлан бодогчийг холбогдох хуулийн шаардлагад нийцүүлэн томилох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 02 -ний өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөнхий журналаас бусад орлогыг орлогын дэлгэрэнгүй тайлантай тулган шалгахад 20,377.2 мянга, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 12.0 мянган, дутуу тайлагнасан	1	20,389.2			1	20,389.2	1	20,389.2				
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дэлгэрэнгүй бүртгэлд 14,432.8 мянган төгрөгийн удирдлага борлуулалтын зардлыг, удирдлага борлуулалтын зардалд 446.0 мянган төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	14,878.8			1	14,878.8	1	14,878.8				
3	Санхүүгийн байдлын тайланд тусгасан авлагын бүртгэлийн үлдэгдлээс түүвэрлэн ААН-ын авлагын бүртгэлийг тулган шалгахад 501,173.6 мянган төгрөгийг өөрийн байгууллагаас авахаар бүртгэсэн	1	501,173.6			1	501,173.6	1	501,173.6				
	Дүн	3	536,441.6			3	536,441.6	3	536,441.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

1	Санхүүгийн байдлын тайланд тусгасан 344,234.4 мянган төгрөгийн авлага, 1,089,765.1 мянган төгрөгийн богино хугацаат өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан нь баримтаар нотлогдохгүй	1	1,433,999.5			1	1,433,999.5						
2	Мөнгөн хөрөнгөөс түүвэрлэн шалгахад 155 гүйлгээ буюу 1,109,456.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтаар нотлогдохгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн	1	1,109,456.4			1	1,109,456.4						
3	Тайлант онд 3 ерөнхий нягтлан бодогч, 1 нярав солигдоход 49,736,658.5 мянган төгрөгийн эд хөрөнгийн болон төлбөр тооцооны талаар тооллого хийсэн эсэх нь баримтаар нотлогдохгүй	1	49,736,658.5			1	49,736,658.5						
4	Сөрөг санал дүгнэлт авсан албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах	1	0							1	0		
5	Тайлант хугацаанд ажилласан ерөнхий нягтлан бодогч нар хуульд заасан шаардлага хангаагүй	1	0					1	0				
Дүн		5	52,280,114.4			3	52,280,114.4	1	0	1	0		

